

ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХ АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЛАЛ

1. Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй аудитын хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.
2. Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээд нь Төсвийн шууд захирагчийн болон Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2020 оны санхүүгийн тайланг УСНББОУС, СТОУС, НББОУС болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.
3. Санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9-д заасан цаглабарт хугацаанд гүйцэтгэнэ.
4. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь дараах материалыг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү. Үүнд:
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
 - Татварын тодорхойлолт;
 - Нийгмийн даатгалын тодорхойлолт;
 - ШШГЕГ-ын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;
 - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
 - ММНБИ-ын тодорхойлолт;
 - Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
 - Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
 - Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
 - Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/;

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 09:00 цагаас 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 17:00 цагийн хооронд авч болох бөгөөд материалаа 2021 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 17:00 цагийн дотор uvs@audit.gov.mn хаягаар цахим хэлбэрээр болон цаасаар ирүүлнэ үү.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар
Утас: 70453317, 70453721